



**ХАРХОРИН СУМ**

**ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ХОРШООНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН Т.БЯМБАСҮРЭНГИЙН 2025 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**2025 ОН**

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

ХАРХОРИН СУМЫН ЗДТГАЗАР (нэгжийн нэр)-н ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ХОРШООНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН (албан тушаалын нэр) ТӨМӨРБААТАР ОВОГТОЙ БЯМБАСҮРЭН (албан хаагчийн овог, нэр)-н 2025 ОНЫ  
СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	
	1	2	3	4	5	6	7
<b>Зорилт 1. "Хүнс, худалдаа үйлчилгээ, хөнгөн үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, удирдан зохион байгуулна."</b>							
1.	Арга хэмжээ 1.1. Монгол Улсын Засгийн газрын болон Өвөрхангай аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Өвөрхангай аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнөөс суманд хамаарал бүхий заалтуудаас түүвэрлэн авч төлөвлөгөө гаргаж, үр дүнг тооцоон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, сумын Засаг даргын Тамгын газарт тайлагнах.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	100%	100%	Монгол Улсын Засгийн газрын болон Өвөрхангай аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Хамтран ажиллах гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Өвөрхангай аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнөөс суманд хамаарал бүхий заалтуудын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.Ахуй үйлчилгээ, жижиг дунд үйлдвэр, мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, барилга, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 521 иргэн 135 аж ахуй нэгжүүдийн судалгааг	эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05	100

2.	<p>Арга хэмжээ 1.2.-Тухайн орон нутгийн иргэдийн үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг үе шаттай, тогтмол зохион байгуулах</p>	Сургалтын тоо	2	42	<p>тусгай маягтын дагуу авч нэгтгэн мэдээллийн санд баяжилт хийлээ.</p> <p>"Хөгжлийн шийдэл" ТББайгууллагатай хамтран аж ахуйн нэгж, компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэлээр 23 удаагийн бүлгийн болон ганцаарчилсан, цахим сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 485 иргэнийг хамруулсан. Сумын ИТХУрлын 2025 оны 03 дугаар сарын 27-ний 03/05 дугаар тогтоол, сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн А/95 дугаар захирамжаар газар тариалан малын тэжээлийн үйлдвэр байгуулах, оёдлын цех, ажлын байр барих, цэвэр усны үйлдвэр өргөтгөх тоног төхөөрөмж шинэчлэх чиглэлээр 3 хоршоонд 470,0 сая төгрөгийн зээл олгож 14 шинэ болон түр ажлын байр бий боллоо. Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний хяналтын Улсын байцаагчтай хамтран "Хоол</p>	<p>эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05</p> <p>100</p>
----	---	---------------	---	----	---	--

				<p>Үйлдвэрлэл, хүнсний чанар, стандарт, дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам” сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтад хоол үйлдвэрлэгч, хүнсний цех, өрхийн үйлдвэрлэл, хоршооны төлөөлөл 45 иргэн хамрагдлаа.</p>		
<p>3.</p>	<p>Арга хэмжээ 1.3. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний худалдааны цэг, сагбаруудаас 7 хоног бүр хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг нэгтгэн авч, тухай бүр үнэн зөв бодитой мэдээлж, хангамж, нийлүүлэлтийн тэнцлийг үйлдвэрлэл, худалдааны тоо хэмжээнд үндэслэн улирал тутам бодитой тооцож ажилласан байх</p>	<p>Үндсэн арга хэмжээний эзлэх гүйцэтгэлд хувь</p>	<p>100%</p>	<p>Хүнсний гол нэрийн 18 төрлийн бүтээгдэхүүнийг 7 хоног бүр авч нэгтгэн ӨВХХАА-н газарт хүргүүлээд байгаа ба хүнсний нөөцийн хангалт 93.8%-тай байна. Эхний хагас жилийн байдлаар хүнсний нөөцийг төрөл тус бүрээр нь авч үзвэл адууны мах 1,6 тн, үхрийн мах 1,8 тн, хонины мах 1,6 тн, ямааны мах 2,1 тн, сүү, сүүн бүтээгдэхүүн-0,31 мян.тн, гурил, гурилан бүтээгдэхүүн-0,18тн, жимс, жимсгэнийн бүтээгдэхүүн-14,5 тн нөөцтэй байна.Мөн нөөцийн мах бэлтгэх ажлын хүрээнд 7 хоног бүр мэдээг авч нэгтгэн холбогдох газарт уламжилж байгаа ба “Алга дүүрэг” хоршоо нь жилийн</p>	<p>эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05</p>	<p>100</p>

				<p>эцсийн байдлаар: Хонь - 3751 толгой, 86,2 тн, Ямаа-976 толгой, 14,6 тн, Үхэр-319 толгой, 47,8 тн, Адуу-113 толгой, 16,9 тн, Тэмээ-12 толгой, 2,4 тн мал махыг бэлтгэн нийлүүлж үйл ажиллагаа нь тогтворжоод байгаа ба 6 иргэнийг түр, 3 иргэнийг байнгын ажлын байраар ханган ажиллаж байна.</p>		
<p>4. Арга хэмжээ 1.4. Хоршоог хөгжүүлэх сангийн төсөл зарлах, хүлээн авах, эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлүүлэх, мэдээллийн санд оруулж мэдээлэх, хяналт тавих, тайлагнах</p>		<p>1.Зохион байгуулсан арга хэмжээний хувь</p>	<p>2%</p>	<p>2%</p>	<p>Сумын ИТХУрлын 2025 оны 03 дугаар сарын 27-ний 03/05 дугаар тогтоол, сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн А/95 дугаар захирамжаар газар тариалан малын тэжээлийн үйлдвэр байгуулах, оёдлын цех, ажлын байр барих, цэвэр усны үйлдвэр өргөтгөх тоног төхөөрөмж шинэчлэх чиглэлээр 3 хоршоонд 470,0 сая төгрөгийн зээл олгож 14 шинэ болон түр ажлын байр бий боллоо.Хоршоог хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлттэй байсан 11 зээлийн 13783 сая төгрөгийн зээлийг бүрэн төвлөрүүлэн ажиллалаа. Тайлент онд 27</p>	<p>эхэлсэн: 2025.06.10 ДУУССАН 2025.12.05 100</p>

					<p>зээлдэгч зээлийн үлдэгдэлтэй байгаа ба зээлийн авлага-1,049,992,113 сая төгрөг зээлийн хүүгийн авлага-70,225,054 сая төгрөг байна. Тус хугацаанд 11 зээлийг хаалгаж сангийн дансанд 137,321,3 сая төгрөгийг төвлөрүүлж 16 зээлдэгчийн 31,7 сая төгрөгийн дүнтэй зээлдэгчийн ангиллыг Монгол банкны зээлийн мэдээллийн санд илгээж хэвийн ангилалд шилжүүлж хугацаа хэтрэлт 0,06 хувьд хүрлээ. Тайлант онд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас хог хаягдал ангилан ялгах 2-догч түүхий эдийг боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Эко Хархорин ХХК-д 70,3 сая төгрөг, Сүүний үйлдвэрийг өргөжүүлэх, малын тэжээл үйлдвэрлэх чиглэлээр Сүүн шим ХХК-д 100,0 сая төгрөгийн зээлийг олгож 2 байнгын 4 түр ажлын байр бий болоод байна.</p>	
5.	Арга хэмжээ 1.5. "Цагаан алт"	Зохион байгуулсан	Монгол Улсын		"Цагаан алт" хөтөлбөрийн	

<p>Үндэсний өрнүүлж, сурталчлан хэмжээг зохион байгуулах орон нутагт таниулах арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>арга хэмжээний тоо, -Олон мэдээллийн сувгийн тоо -Хамрагдсан иргэдийн тоо</p>	<p>Их Хурлын 2024 онд "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 63 дугаар тогтоол батлагдсан.</p>	<p>хүрээнд "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих арьс шир түүхий эдийг чанар, стандартын дагуу бэлтгэх, түүхий эдийн чанарыг сайжруулах чиглэлээр Өвөрхангай аймагт 2025 оны 10 дугаар сарын 20, 21 өдрүүдэд сургалт хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. Мөн мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх чиглэлээр 3 аж ахуй нэгж 1 иргэн үйл ажиллагаа явуулж байгаа ба "Шинээ хоршоо чинээлэг малчин хөтөлбөр"-ийн хүрээнд 2 хоршоо шинээр байгуулагдаж, малын үүлдэр угсааг сайжруулах, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, тоног төхөөрөмж худалдан авах чиглэлээр 20,1 сая төгрөгийн зээл авч үндсэн үйл ажиллагаагаа эхлүүлж 4 ажлын байр хадгалагдаад байна.</p>	<p>эхэлсэн: 2025.06.10 Дууссан 2025.12.05</p> <p>100</p>
<p>6. Арга хэмжээ 1.6. "Шинэ-Хоршоо" хөдөлгөөнийг</p>	<p>- Дэмжлэгт хамрагдсан</p>	<p>Аймгийн хэмжээнд</p>	<p>"Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд" Хөгшний гол</p>	

<p>эрчимжүүлж, санал санаачилгатай малчдыг бүх талаар дэмжих, холбогдох ТББ, мэргэжлийн холбоодтой хамтран хоршоодыг чадавжуулах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>хоршооны тоо, Хөнгөлөлттэй зээлийн хэмжээ (тэрбум төг) Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, Хамрагдсан хоршоодын тоо</p>	<p>2024 онд нийт 215 хоршоо 36.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан байна. Тайлант онд 19 сумын 40 хоршоо сургалт арга хэмжээнд хамрагдсан байна..</p>		<p>хоршоо, Ханбургагайн хишиг хоршоо, Гешон нутаг хоршоо, Усан хавтгайн хишиг хоршоо, Үржин дэлгэрэх өвөр элстий хоршоо, Баян мал аж ахуйн хоршоо, Баяжих баг тулга хоршоо, Цэцэгтсайхан тал ундарга зэрэг 8 хоршоодод тус бүр 5 га газрыг эзэмшүүлээд байна. Сумын төвийн иргэдэд “ Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий талаарх мэдээллийг 150 гаруй иргэдэд хүргэж, хоршоо шинээр байгуулах болон хоршооны гишүүн болох хүсэлтэй 283 иргэдэд ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгч ажилласан.Мөн Архангай аймагт зохион байгуулагдсан хоршоологчдын хангайн бүсийн зөвлөгөөнд “Баяжих баттулга”, Зөөлөн сувд” хоршоо оролцож сайн туршлагын талаар мэдээлэл бэлтгэх хүргэсэн. Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газраас “Олон улсын хоршооллын жил-2025 “-ийн</p>	<p>100</p> <p>эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05</p>
--	--	--	--	--	--

				<p>хүрээнд хоршоодын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах арга хэмжээний хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 03-аас 10 дугаар сарын 06-ний өдрүүдэд Арвайхээр суманд зохион байгуулагдсан бөгөөд тус арга хэмжээнд хоршооны төлөөлөл 1 иргэний хамт оролцож мэдээлэл авч туршлага судалсан. “ХАРХОРИН СУМЫН ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧИД” пэйж хуудас нээн ажиллуулж хоршоог хөгжүүлэх сангийн журам, жижиг дунд бизнес эрхлэгч иргэн, аж ахуй нэгж, хоршоотой холбоотой мэдээллийг тогтмол хүргүүлэн ажиллаж давхардсан тоогоор 200 гаруй иргэн, хоршоонд мэдээлэл хүргэлээ. Өвөрхангай аймгийн Хоршоологчдын холбоотой хамтран хоршооны гишүүдэд сургалт зохион байгууллаа. Тус сургалтаар хоршооны 7 зарчим, хоршоодын цаашид анхаарах асуудлууд, Хоршоог хөгжүүлэх сангийн</p>
--	--	--	--	--

					<p>хөрөнгийг зарцуулах, журмын дүнгийн мэдээлэл өргч, өрнүүлэв.</p>	<p>бүрдүүлэх, хяналт тавих хэрэгжилт, үр талаар 38 иргэнд хэлэлцүүлэг өргч, өрнүүлэв.</p>	
<p><b>Зорилт 2. "Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хүн амын хэрэгцээ хангамжийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг дээшлүүлнэ."</b></p>							
<p>1.</p>	<p>Арга хэмжээ 2.1. "Хөх сав, канистергүй сум, баг, өрх" хөдөлгөөн өрнүүлэх, малчдыг сүү цагаан идээгээ хүнсний зориулалтын саванд боловсруулах, хадгалах, тээвэрлэх чиглэлээр арга хэмжээ авах</p>	<p>-Нөлөөллийн арга хэмжээний тоо, -Зориулалтын бус савыг зориулалтын саваар сольсон айл өрхийн тоо</p>	<p>Сумын хэмжээнд 180 айл өрх, 8 байгууллагын гал тогоо, 5 нийтийн хоолны газар хуванцар савнаас татгалзсан.</p>	<p>2</p>	<p>Сумын Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн А/03 дугаар захирамжаар тусгай удирдамжийн дагуу Татварын алба, Мал эмнэлгийн тасаг, Цагдаагийн хэлтэс, Нийгмийн бодлогын мэргэжилтнүүдтэй хамтран цагаан сарын баярыг угтан нийт 36 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.Хяналт шалгалтаар хадгалах хугацаа хэтэрсэн, хаян шолшгын зөрчилтэй 201 нэр төрлийн 5,8 сая төгрөгийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг устгаж, хадгалалтын горим мөрдөөгүй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэгдэхээс</p>	<p>эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05</p>	<p>100</p>

					<p>урьдчилан сэргийлж ажилласан. Мөн ЕБСургуулийн хүүхдийн үдийн цай, дотуур байр, СӨБайгууллагын хоол үйлдвэрлэлд тавигдах чанар стандарт, хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, хүнсний зориулалтын бус савны хэрэглээнээс татгалзах талаар зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж 639 ширхэг гарын авлага тарааж 3 удаагийн уриалгыг Хархорин мэдээ сайтаар дамжуулан иргэдэд хүргэж ажилласнаар давхардсан тоогоор 1850 гаруй иргэн хамрагдсанаас суманд хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 11 төрийн байгууллага, сумын нийт өрхийн 23% нь хүнсний зориулалтын бус хуванцар савнаас 100% татгалзсан үр дүнтэй байна.</p>	
2.	<p>Арга хэмжээ 2.2. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн, УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргын 2022 оны 606</p>	<p>Төлөвлөгөөний хэрэгжилтийн тухайн жилийн үр дүнгээр</p>	<p>"Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх жил" болгон зарлаж 92%-тай хэрэгжүүлсэн.</p>	-	<p>Сумын Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн А/03 дугаар захирамжаар тусгай удирдамжийн дагуу Татварын алба, Мал</p>	

дугаар захирамжаар  
батлагдсан хүнсний хангамж,  
аюулгүй байдлыг сайжруулах  
"Аймгийн 5 жилийн төлөвлөгөө"-  
ний хэрэгжилтийг орон нутагт  
зохион байгуулах

эмнэлгийн тасаг, Цагдаагийн  
хэлтэс, Нийгмийн бодлогын  
мэргэжилтнүүдтэй хамтран  
цагаан сарын баярыг угтан  
нийт 36 иргэн, аж ахуйн  
нэгжийн үйл ажиллагаанд  
урьдчилан сэргийлэх  
шалгалт хийж, мэргэжил арга  
зүйн зөвлөмж өгч  
ажиллалаа.Хяналт  
шалгалтаар хадгалах  
хугацаа хэтэрсэн, хаян  
шошгын зөрчилтэй 201 нэр  
төрлийн 5,8 сая төгрөгийн  
хүнсний түүхий эд,  
бүтээгдэхүүнийг устгаж,  
хадгалалтын горим  
мөрдөөгүй бүтээгдэхүүнийг  
зах зээлд нийлүүлэгдэхээс  
урьдчилан сэргийлж  
ажилласан.Мөн  
ЕБСургуулийн хүүхдийн  
үдийн цай, дотуур байр,  
СӨБайгууллагын хоол  
үйлдвэрлэлд тавигдах чанар  
стандарт, хүнсний  
бүтээгдэхүүний хадгалалт  
хамгаалалтын талаар зөвлөн  
туслах үйл ажиллагааг  
зохион байгууллаа.Тус онд  
хоршоог хөгжүүлэх сангаас  
цэвэр усны үйлдвэр өргөтгөх  
чиглэлээр 125,0 сая  
төгрөгийн зээлийг олгож 4

эхэлсэн:  
2025.06.10  
дууссан  
2025.12.05

100

3.	Арга хэмжээ 2.3. "Намрын ногоон өдрүүд-2024" улсын хэмжээний нэгдсэн арга	Аймаг, улс бүсийн үзэсгэлэнд 3 аж ахуй нэгж, 5	Үзэсгэлэн худалдаанд оролцох		ажлын байр хадгалагдаж, 2 түр ажлын байр бий боллоо. Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний хяналтын Улсын байцаагчтай хамтран "Хоол үйлдвэрлэл, хүнсний чанар, стандарт, дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам" сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтад хоол үйлдвэрлэгч, хүнсний цех, өрхийн үйлдвэрлэл, хоршооны төлөөлөл 45 иргэн хамрагдлаа. "ИМПОРТЫН ХҮНСНИЙ ХУДАЛДААЛАЛТ-ХЯНАЛТ" арга хэмжээг Өвөрхангай аймгийн Хяналтын албатай хамтран 2025 оны 09 дүгээр сарын 30-ний өдөр суманд хүнсний худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 30 аж ахуй нэгжүүдэд сургалт зохион байгуулж 5 объектод хяналт шалгалт зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан.	
					"Хархорины намар-2025" үзэсгэлэн худалдааг хамтран зохион байгуулсан	

	<p>хэмжээний хүрээнд сум орон нутагтаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, шалгарсан бүтээгдэхүүнийг улс, бүс, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцуулахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>доошгүй иргэн оролцсон байна.</p>	<p>бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, сурталчлах, дэмжлэг үзүүлж ажилласан байна.</p>		<p>2025 оны 09 дүгээр сарын 25-26-ний өдрүүдэд "Соёлын төв" д тус арга хэмжээг зохион байгуулсан. Үзэсгэлэнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 5 хоршоо, 46 иргэн 121 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 21,7 сая төгрөгийн борлуулалт хийлээ. Дайвар бүтээгдэхүүн боловсруулах 2 иргэний үйл ажиллагаа тогтмолжиж, тус арга хэмжээний үеэр 1,8 сая төгрөгийн борлуулалт хийлээ.</p>	<p>эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05</p>	<p>100</p>
<p>4.</p>	<p>Арга хэмжээ 2.4. Хүнсний үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах талаар хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, заавар өгч хамтран ажиллах</p>	<p>Дэмжлэгт хамрагдсан үйлдвэр, аж ахуй нэгжийн тоо, дэмжлэгийн хэмжээ(төгрөгөөр)</p>	<p>2023 онд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 1 аж ахуй нэгжид 48,0 сая төгрөг Хоршоог хөгжүүлэх сангаас 1 хоршоо 10 иргэнд 263,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.</p>	<p>2 хоршоонд 363,0 сая төгрөг олгосон</p>	<p>Сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн А/95 дугаар захирамжаар Хоршоог хөгжүүлэх сангаас цэвэр усны үйлдвэрийг өргөтгөх чиглэлээр 1 хоршоонд 125,0 сая төгрөгийн дэмжлэгт хамруулж 6 иргэнийг түр болон байнгын ажлын байраар ханган ажиллаж байна.Сүүлийн хагас жилийн байдлаар гурил гурилан бүтээгдэхүүний 1 цех 21,8 сая төгрөгийн хувь хөрөнгө оруулалтаар өргөтгөл хийж бүтээгдэхүүний нэр төрлөө 2-оор нэмэгдүүлээд байна.Өв аймгийн Стандарт хэмжил</p>	<p>эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05</p>	<p>100</p>

					<p>зүйн хэлтэст тохирлын гэрчилгээний хугацаа дууссан болон шинээр авах хүсэлт гаргасан 12 иргэн, аж ахуй нэгжүүдийн материалыг хугацаанд нь хүргүүлэн үнэлгээг хийлгүүлж хүнсний аюулгүй байдлыг хангах талаар хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, заавар өгч хамтран ажилласан. Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний хяналтын Улсын байцаагчтай хамтран "Хоол үйлдвэрлэл, хүнсний чанар, стандарт, дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам" сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтад хоол үйлдвэрлэгч, хүнсний цех, өрхийн үйлдвэрлэл, хоршооны төлөөлөл 45 иргэн хамрагдлаа.</p>	
5.	<p>Арга хэмжээ 2.5. Монгол үндэсний уламжлалт (орон нутгийн онцлогтой) хоол, идээ ундааг түгээн дэлгэрүүлж, хүнсний зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Зохион байгуулсан сургалтын тоогоор</p>	2	2	<p>Монгол үндэсний уламжлалт (орон нутгийн онцлогтой) хоол, идээ ундааг түгээн дэлгэрүүлж, хүнсний зохистой хэрэглээний талаар 2 удаагийн зурагт хуудас цахимд нийтлэн 231 гаруй иргэн үзсэн ба хүнсний худалдаа эрхлэгч нарт мэдээлэл өгсөн.Сүү хөтөлбөрийн хүрээнд</p>	<p>эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05</p> <p>100</p>

							Ерөнхий боловсролын 4 сургууль, СӨБоловсролын 5 цэцэрлэгт хүүхдэд өдөрт 1 аяга сүүг өгөх арга хэмжээг эцэг эхийн зөвлөлүүдтэй хамтран хэрэгжүүлж нийт 2139 хүүхдийг бүрэн хамруулж байна.		
<b>Зорилт 3. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллана.</b>									
1.	Арга хэмжээ 3.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	50%	50%			Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах төлөвлөгөөний биелэлт, бодлогын 8 баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.	эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05	100
2.	Арга хэмжээ 3.2. Албан бичгийн боловсруулалтад Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS 5140-1:2021 баримт бичгийн стандартыг Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг өгөх, шаардлагатай тохиолдолд холбогдох	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	50%	50%			Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглаж Монгол улсын Их хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай шинэчилсэн найруулгыг бие даан судалсан.Хоршоог хөгжүүлэх сангаас		

	<p>төрийн байгууллага, албан хаагчдаас тухай бүр тодруулга, мэдээлэл авч шийдвэрлэлтэд ахиц гаргах мөрдөж ажилласан байдал.</p>				<p>хөнгөлөлттэй зээл хүссэн 3 аж ахуй нэгжийн хүсэлт зээлийн ангилал солиулах хүсэлтэй гаргасан 16 зээлдэгчийн 31,7 сая төгрөгийн дүнтэй зээлдэгчийн ангиллыг Монгол банкны зээлийн мэдээллийн санд илгээж хэвийн ангилалд шилжүүлсэн.Сүүлийн хагас жилийн байдлаар Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 6 аж ахуй нэгжийн хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлүүлэн ажилласан. Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхтэй холбоотой тусгай зөвшөөрөл хүссэн 11 аж ахуй нэгжийн хүсэлтийг хүлээн авч хариуцлагатай үйлчилгээний сургалтад 20 иргэнийг хамруулахаар бэлтгэл ажил хангагдаж байна.</p>	<p>эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05</p>	<p>100</p>
--	---	--	--	--	--	---	------------

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
-----	-------------------------------	------------------	--------------	--------------	-------------------------	--------------------------	-----------------

1.	Арга хэмжээ 1. Бүх нийтийн хог цэвэрлэх ажилд хуваарийн дагуу оролцох	Оролцсон тоогоор	1	1	Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулах ажлын хүрээнд 2 удаа ажил үүргийн хуваарийн дагуу 1 дүгээр багт. ажиллаж айл өрхүүдийг хог цэвэрлэгээнд хяналт тавин ажиллаж хариуцсан албан хаагчдад нь хүлээлгэн өгч иргэдийн санал хүсэлтийг тухай бүр нь танилцуулан ажилласан.	эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05	100
2.	Арга хэмжээ 2. Бүх нийтийн мод тарих ажилд оролцох	Оролцсон тоогоор	1	1	Сумын хэмжээнд зохион байгуулсан бүх нийтийн мод тарих ажилд ажил үүргийн дагуу оролцсон.	эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05	100
3.	Арга хэмжээ 3. Сумын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд оролцох.	Оролцсон тоогоор	3	3	2025 оны 05 дугаар сарын 20-21 өдрүүдэд зохион байгуулсан "Хүний эрхийн төлөө хамтдаа" нээлттэй өдөрлөг, 2025 оны 05 дугаар сарын 13-нд зохион байгуулагдсан Өв аймгийн "ГХУСАЗСЗөвлөл"-ийн сургалт, 2025 оны 04 дүгээр сарын 15-нд зохион байгуулсан Өв аймгийн "Хөдөлмөрийн хэлтэс"-ийн нээлттэй хаалганы өдөрлөг 2025 оны 03 дугаар сарын 27-ний өдөр зохион байгуулсан "Төрийн албаны зөвлөл"-ийн зэрэг 4 удаагийн сургалт.	эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05	100

							хэлэлцүүлэг, өдөрлөгүүдэд оролцож мэдээлэл авсан.	
--	--	--	--	--	--	--	---	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
1.	Арга хэмжээ 1.1. Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа хууль тогтоомжуудыг судлан хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	3	4	5	6	7
			100%	100%	Тамхины хяналтын тухай 2005.07.01 Сogгууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согуурахтай тэмцэх тухай 2022.07.05."Архидан согуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай"2017.02.01. №46" Цагаан алт" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, орон нутагт сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах"Шинэ-Хоршоо" хөдөлгөөнийг эрчимжүүлж, санал санаачилгатай малчдыг бүх талаар дэмжих, холбогдох ТББ, мэргэжлийн холбоодтой хамтран хоршоодыг чадавхжуулах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах Монгол улсын	эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05	100

					<p>Ерөнхийлөгчийн санаачилгаар “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн, УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргын 2022 оны 606 дугаар захирамжаар батлагдсан хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах “Аймгийн 5 жилийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах зэрэг бодлогын баримт бичиг, Хүнсний чанар стандартын хүрээнд 6 стандартыг бие даан судлан хэрэгжүүлж хууль зүйн мэдлэгээ дээшлүүлж байна.</p>	
2.	<p>Арга хэмжээ 2.1. Хоршоог хөгжүүлэх сангийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, ашиглах мэдлэгээ дээшлүүлэх, сургалт, зөвлөгөөнд тогтмол хамрагдах.</p>	<p>Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь</p>	<p>100%</p>	<p>100%</p>	<p>2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Өв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийн нэгдсэн зөвлөгөөн, салбар дундын сургалтад амжилттай хамрагдаж цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл авсан.Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих</p>	

			<p>арьс шир түүхий эдийг чанар, стандартын дагуу бэлтгэх, түүхий эдийн чанарыг сайжруулах чиглэлээр Өвөрхангай аймагт 2025 оны 10 дугаар сарын 20, 21 өдрүүдэд сургалт хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд сумаас 2 малчин, хоршооны төлөөлөл оролцсон. Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газраас "Олон улсын хоршооллын жил-2025"-ийн хүрээнд хоршоодын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах арга хэмжээний хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 03-аас 10 дугаар сарын 06-ний өдрүүдэд Арвайхээр суманд зохион байгуулагдсан бөгөөд тус арга хэмжээнд хоршооны төлөөлөл 1 иргэний хамт оролцож мэдээлэл авч туршлага судалсан.</p>	<p>эхэлсэн: 2025.06.10 дууссан 2025.12.05</p>	<p>100</p>
--	--	--	--	---	------------

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ  
ХОРШООНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН  
( Албан тушаал )

..... / Т.БЯМБАСҮРЭН /

2025 он 12 дугаар сарын .... өдөр

( Нэр, гарын үсэг )

( Огноо )